УУЛ УУРХАЙН АВРАХ АНГИЙН АЛБАНЫ ДАРГА АВРАХ АНГИЙН
УДИРДАГЧ, АХМАД................Д.БАЯРЖАРГАЛ
БОЛОВСРУУЛСАН:
БОХАБЭАХ-ИЙН ИНЖЕНЕР................Т.ГАНСҮХ

2024 ОН

БАТЛАВ:
"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
................Г.ДУГАРЖАВ

БАТЛАВ:
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ УУЛ УУРХАЙН АВРАХ АНГИЙН ЗАХИРАГЧ ХУРАНДАА
................Д.ГАНТУЛГА

ДАРХАН УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨРТОЛГОЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ИЛ УУРХАЙН 2024 ОНЫ БОЛЗОШГҮЙ АЮУЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХЯНАСАН:
УУҮТХ-ИЙН ДАРГА................Г.ХИШИГБАЯР
БОХАБЭАХ-ИЙН ДАРГА................Н.БАТЦЭНД
УУРХАЙН ДАРГА................А.БИЛГҮҮН
УУЛ УУРХАЙН АВРАХ АНГИЙН АЛБАНЫ ДАРГА АВРАХ АНГИЙН
УДИРДАГЧ, АХМАД................Д.БАЯРЖАРГАЛ
БОЛОВСРУУЛСАН:
БОХАБЭАХ-ИЙН ИНЖЕНЕР................Т.ГАНСҮХ

2024 ОН

*Зураг 38 Уурхайн болзошгүй аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө*


Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0013982

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: Дархан төмөрлөгийн үйлдвэр ХК
Хаяг: Хонгор сум 1-р баг
Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: ТТХУурхайн ШТС

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, / гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж /анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно. /Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3/

Олгосон: 2023 он 12 сар 27 өдөр
Хүчинтэй хугацаа: 2025 он 12 сар 26 өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:
Дархан-Уул аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ дарга Хурандаа цолтой С.Пүрэвсамдан

Дүгнэлт гаргасан:
Дархан-Уул аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ Гал түймрийн улсын хяналтын байцаагч Хошууч цолтой Ц.Идэш

/тэмдэг дарна/

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0010181

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: Дархан Төмөрлөгийн үйлдвэр ТӨХК
Хаяг: Хонгор сум, 1-р баг Төмөр толгой
Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: Хүдрийн ил уурхай Төмөрлөгийн үйлдвэрлэл

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, / гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж /анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно. /Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3/

Олгосон: 2023 он 09 сар 07 өдөр
Хүчинтэй хугацаа: 2025 он 09 сар 06 өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:
Дархан-Уул аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ дарга Хурандаа цолтой С.Пүрэвсамдан

Дүгнэлт гаргасан:
Дархан-Уул аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ Гал түймрийн улсын хяналтын байцаагч Хошууч цолтой Ц.Идэш

/тэмдэг дарна/

*Зураг 39 Уурхайн галын аюулгүй байдлыг дүгнэлт*

## 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх ажлууд | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт | Зардал, төг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Хонгор сумын ТҮГ-тай "Хог хаягдлын гэрээ" байгуулан, гэрээний дагуу хог хаягдлыг төвлөрсөн цэгт зөөж зайлуулах, тээвэрлүүлэх | Гэрээг байгуулан гэрээ 7 удаа хог хаягдлаа ачуулсан. | 3,640,000 | Хог хаягдлын гэрээг доор хавсаргав |
| 2 | Эдэлбэр газар, түүний эргэн тойрны хариуцан хамгаалах талбайн цэвэрлэгээг хийх | Хавар 2024.04 сард Хаврын их цэвэрлэгээг зохион байгуулж нийт 90 орчим ажилтан оролцон 30м$^3$ орчим хог хаягдал цэвэрлэсэн. | Дотоод зардал | Хаврын их цэвэрлэгээ хийж байх үеийн зургийг Зураг 41-д хавсаргав |
| 3 | Хог хаягдлын талаар ажилчдад мэдээлэл түгээх, танилцуулга хийх | Бүх ажилчдын сургалтанд Байгаль орчны чиглэлээр сургалтанд оруулсан. | Дотоод зардал | |
| 4 | Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлж ойр орчмыг тогтмол цэвэрлэж байх | Хог хаягдлын цэгийн хог ачуулж суларсан бүрт ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. Мөн уурхайн бүх ажилчид 7 хоног бүрийн Пүрэв гариг бүрт талбайн цэвэрлэгээг тогтмол хийж байна. | Дотоод зардал | |
| 5 | Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид ангилан нийлүүлэх | Хог хаягдлын савыг дотоод боломжоор сайжруулан, хуванцар хог хаягдлыг тусгай савнуудад хуримтлуулан Компанийн төв байрлуу өгч "SESL" ХХК-д гэрээний дагуу дахин боловсруулалтанд ачуулсан | Дотоод зардал | |
| 6 | ШТМ-ын хаягдал ангилан цуглуулах талбайд төмөр сав бэлдэн хадгалж мэргэжлийн байгууллагад нийлүүлэх | - | Дотоод зардал | Мэргэжлийн байгууллагатай байгуулсан гэрээг зураг 44-д оруулав. |
| 7 | Хаягдал тос, аюултай хог хаягдлын цэгийг шинэчлэн байгуулах | Тусгайлан бэлтгэсэн бетонжуулсан талбайд ачааны машины тэвшийг ашиглан ШТМ-ын хаягдал цуглуулах сав хийсэн. Хаягдлын ЮТО ХХК-д нийлүүлж байна. | 4,500,000 | |
| 8 | Засварын талбай, авто зогсоолын талбайд хагарал үүсэж хөрс хүнд металлаар бохирдохоос сэргийлж байнгын хяналт хийж талбайг нягталж байх | Уурхайн засварын механик, ХАБЭА инженер нар тогтмол үзлэг хийдэг | Дотоод зардал | |
| **НИЙТ** | | | **8,140,000** | |



БАТЛАВ
Хонгор сумын "Хонгор хот тохижилт"
ОНӨААТҮГ-ын дарга
/Д. Ариунболд/

БАТЛАВ

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДЛЫГ
ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

2024 оны .... сарын .... ны өдөр №.... Хонгор сум

Энэхүү гэрээг нэг талаас хуулийн этгээдийн .... улсын бүртгэлийн дугаар .... регистрийн дугаартай Дархан- Уул аймаг Хонгор сум "Хонгор Хот Тохижилт" ОНӨААТҮГ (цаашид үйлчлэгч ) тал гэх түүнийг төлөөлж Хог хаягдлын үйлчилгээний зохион байгуулагч Гансүх овогтой Нарантуяа нөгөө талаас хуулийн этгээдийн.... улсын бүртгэлийн дугаар .... регистрийн дугаартай .... түүнийг төлөөлж .... Албан тушаалтай.... овогтой .... (цаашид " Үйлчлүүлэгч) тал гэх нар Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж дүрэм журмыг удирдлага болгон дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

**Нэг: Гэрээний ерөнхий нөхцөл**

1.1. Энгийн хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх тусгай зөвшөөрөл Дархан-Уул аймаг Хонгор сумын "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ нь үйл ажиллагааны үндсэн чиглэл, хог хаягдлыг тухай хуулийн хүрээнд захиалагч ....н өдөр тутмын ахуйн хог хаягдлыг татан зайлуулах

1.2. Захиалагч тал хогоо тээвэрлүүлэхээр дуудлага өгсөн тохиолдолд "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ зориулалтын тээврийн хэрэгслээр захиалагчийн хог хаягдлыг татан зайлуулах.

**Хоёр: Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг.**

2.1. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий "Хонгор Хот Тохижилт" ОНӨААТҮГ-тай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах;
2.2. Шаардлага хангасан хогийн савтай байх; хог хаягдлыг ачих нөхцөл боломжоор хангасан байх
2.3. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд нь төлөх;
2.4. Нийтийг хамарсан цэвэрлэгээ, зохион байгуулалттай үйл ажиллагаанд хариуцлагатайгаар оролцох;
2.5. Байгууллагын орчны 50м дахь нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөс, хог ургамлыг цэвэрлэх,устгах
2.6. Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг



"Хонгор Хот Тохижилт" ОНӨААТҮГ-д шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах;
2.7. Энгийн хог хаягдлаа ангилан ялгах;

**3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараах үйл ажиллагааг хориглоно:**

3.1. Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях;
3.2. Нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан суваг хог хаягдал хаях;
3.3. Хог хаягдлыг ил задгай шатаах;
3.4. Хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях;

**Дөрөв : Тээвэрлэгчийн эрх, үүрэг.**

4.1. Хог, хаягдлыг цуглуулах, ачих, тээвэрлэх, төвлөрсөн цэгт хаях, буулгах түрж булах устгах ажлыг зохион байгуулах
4.2. Гэрээ болон бусад хууль тогтоомжийн дагуу хог хаягдлыг цуглуулах, ачих, тээвэрлэх, төвлөрсөн цэгт хаях, буулгах үйлчилгээ үзүүлсний хураамж авах
4.3. Хууль тогтоомж, гэрээний үүргийн биелэлтийн талаар үйлчлүүлэгчид шаардлага тавих,
4.4. Хогоо татан зайлуулах захиалга хүлээж авснаас 2-5 хоногт багтаан үйлчлүүлэгчийн хог хаягдлыг татан зайлуулна.
4.5. Сумын ИТХ-ын тогтоолыг үндэслэн: Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ нь /тогтмол жилээр, тогтмол сараар, рейсээр , мкуб-аар / ангилал, төрөл, хугацаа, зайнаас хамааруулан .... ....төгрөг байна.

Тав: **Хариуцлага.**

4.1. Зориулалтын бус газар хог хаягдал хаясан гаргасан бол Хог хаягдлын тухай хуулийн 23-р зүйлийн 23.1.1-д заасны дагуу иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-5 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр, ААН Байгууллагыг 5-10 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр торгож, учирсан хохирлыг арилгуулах

4.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хууль тогтоомжийн дагуу, хариуцлага тооцож, төлөх үнийн дүнд 0.5 хувиар алданги тооцон төлүүлэх

Зургаа : Сунгалт

**Зургаа: Гэрээ байгуулсан.**

Хонгор Сумын "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ-ыг төлөөлж
/Г.Нарантуяа/
Утас 99372324

Аж ахуй нэгжийг төлөөлж
Утас: ....

*Зураг 40 Хог хаягдлыг тээвэрлэх гэрээ*



*Зураг 41 Хаврын их цэвэрлэгээ хийж буй нь*



БАТЛАВ

"ЭС И ЭС ЭЛ СМАРТ СОЛЮШН" ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

________ /Ч. АГИЙМАА/

БАТЛАВ

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК

________ /Г. Дугаржав/

**ХУВАНЦАР САВ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2023 оны 07 сарын 06 өдөр **SESL-23/....** Улаанбаатар хот

Энэхүү хуванцар сав нийлүүлэх гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г

Нэг талаас, "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК (РД:6990916) /цаашид "Худалдан авагч" гэх/, түүнийг төлөөлж Худалдааны төлөөлөгч О.Амарсайхан

Нөгөө талаас, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК (РД: 2051303) /цаашид "Нийлүүлэгч" гэх/, түүнийг төлөөлж БОХАБЭАА-ны дарга Н.Батзэжэг хамтад нь "Талууд" гэх/ нар харилцан тохиролцож байгуулав.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 Энэхүү гэрээний зорилго нь нийлүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан, худалдан авагчийн шаардлагыг хангахуйц PET1 тэмдэглэгээ бүхий ундаа, усны хуванцар сав, бор энгийн картон цаас, бүх төрлийн лаазыг хүлээлгэж өгөх, худалдан авагч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх болон бусад харилцааг зохицуулахад оршино.

**ХОЁР. ТӨЛБӨР ТООЦОО, ХУГАЦАА**

2.1 1кг хуванцар савны үнэ ...450 / 500.............../ төгрөг байна.

2.2 Нийлүүлэгч төлбөр төлөгдсөнөөс хойш ажлын 3 хоногийн дотор и-баримтыг шивнэ.

2.3 ***Төлбөр төлөх нөхцөл:*** Хуванцар савыг хүлээлгэж өгснөөс хойш ажлын 3 хоногийн дотор төлбөрийг шилжүүлнэ.

2.4 ***Төлбөр төлөх данс:*** Нийлүүлэгчийн ...3096015653 тоот "ДТҮ" ХХК дансны нэртэй "...Капитрон..." банкны дансаар төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ.

2.5 ***Гэрээний хугацаа:*** Энэхүү гэрээ нь баталгаажсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.

2.6 Гэрээний хугацаа дуусах үед талууд ямар нэгэн санал гаргаагүй бол гэрээ дахин 1 жилээр сунгагдана.

2.7 Гэрээний төлбөрийг нэмэх, хасах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдэх бөгөөд зөвхөн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулснаар шинэ төлбөрийн нөхцөл болон дүн баталгаажна.

2.8 Нийлүүлэгчийн хүлээлгэж өгсөн хуванцар савнууд дунд өөр төрлийн хуванцар сав болон хэт бохирдсон хуванцар сав нь 2кг–аас хэтэрсэн тохиолдолд энэ талаар мэдээллийг Худалдан авагч нь Нийлүүлэгчид мэдэгдэж нийт хэмжээгээр хорогдолд тооцож төлбөрийг төлнө.

**ГУРАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ**

3.1 **Нийлүүлэгчийн хүлээх үүрэг**

3.1.1 Нийлүүлэгч нь зөвхөн PET1 тэмдэглэгээ бүхий ундаа, усны хуванцар савыг цуглуулж, хүлээлгэж өгөх бөгөөд бусад төрлийн хуванцар савыг холихгүй байх үүрэгтэй.

1/2

*Зураг 42 Хуванцар хог хаягдал нийлүүлэх гэрээ*



*Зураг 43 Хуванцар савнуудыг ачуулж буй байдал*



"ЮТО" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
/Ө.БАТСАЙХАН/

"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХК-ийн ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
/М.ОТГОНБАЯР/

**ТЕХНИКИЙН ХАЯГДАЛ ТОС**
**БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

*2021 оны 10-р сарын 12-ны өдөр* № *Улаанбаатар хот.*

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 5003032 тоот регистрийн дугаартай **"ЮТО" ХХК-** г төлөөлж Гүйцэтгэх захирал Ө.Батсайхан, нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 6298141 тоот регистрийн дугаартай **"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХК** -г төлөөлж Ерөнхий захирал М.Отгонбаяр нар дор дурдсан зүйлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын Иргэний Монгол улсын Иргэний хуулийн 243-264 дүгээр зүйл заалтыг баримтлан энэхүү техникийн ажилласан тос бэлтгэн нийлүүлэх гэрээг байгуулав.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 Энэхүү гэрээгээр **"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХК** (цаашид **ХУДАЛДАН АВАГЧ** гэх) болон **"ЮТО" ХХК** (цаашид **НИЙЛҮҮЛЭГЧ** гэх) нарын гэрээнд заасан хугацаанд машин механизмын, тоног төхөөрөмжийн, хөдөлгүүрийн, гидрийн болон моторын тосыг солих үед гарах техникийн хаягдал тос буюу аюултай хог хаягдал /цаашид "АХХ" гэх/-г цуглуулах, тээвэрлэх, бэлтгэн нийлүүлэх, түүнд тохирох үнийг төлөх болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино.
1.2 Энэхүү гэрээ нь талуудын хооронд хийгдсэн тохиролцоонуудыг агуулж байгаа бөгөөд энэхүү гэрээнд тодорхой байдлаар тусгаж оруулсан заалтуудыг оролцуулахгүйгээр Үйлчилгээтэй холбоотой хэлцэл, мэдэгдэл, аман болон бичгээр хийсэн тохиролцоог энэхүү гэрээ орлож байгаа болно.
1.3 Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, хоёр тал гарын үсэг зураагүй бол тэдгээрийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

**ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА**

2.1 Гэрээ нь **"ЮТО" ХХК** болон **"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХК** -ийн төлөөлөлүүд гарын үсэг зурснаар хугацаагүй хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
2.2 Гэрээнд оролцогч талууд Монгол Улсын Иргэний хуульд зааснаар гэрээний үүргээ бүрэн буюу хэсэгчлэн биелүүлээгүй гэж үзсэн тохиолдолд гэрээг дуусгавар болгохыг санал болгох эрхтэй.
2.3 Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд гэрээг үргэлжлүүлэх эсэх талаар харилцан мэдэгдэл ирүүлээгүй тохиолдолд гэрээ анх байгуулагдсан хугацаагаар сунгагдсанд тооцно.
2.4 Энэхүү гэрээний нөхцөл, болзол, заалтаас татгалзан дуусгавар болгох тухай санал, шалтгааныг талууд зөвхөн албан бичгээр тайлбарлан гаргана.

тушаал, тогтоол эсхүл Засгийн газрын эрх бүхий байгууллагын журам эсхүл зөвшөөрлийг алдах явдал бөгөөд энэ бүхэн аль ч талын үйлдэлд үндэслэгдээгүй байх ёстой.
5.3 Дээрхээс шалтгаалах ажил зогсоолт эсхүл энэ гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээний гүйцэтгэл тасалдсаны улмаас цаг хугацааны хувьд хойшлогдох асуудлыг аль болох яаралтай засаж залруулна.

**ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ**

6.1 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
6.2 Энэхүү гэрээнд заасан хэлцлүүд хэрэгжсэн эсэхийг үл харгалзан гэрээнд тусгагдсан болон гэрээг бэлтгэх, хэрэгжүүлэх үед гэрээнд оролцогч талуудын зүгээс гарсан аливаа зардлыг талууд өөр өөрсдөө хариуцна.

**ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ**

7.1 Талууд харилцагч талынхаа бизнесийн нэр хүндийг хүндэтгэж, тэгш эрхийн зарчимд тулгуурлан ажиллана.
7.2 Талууд гэрээний хугацаанд харилцан ашигтай, найрсаг байдлаар хамтран ажиллаж аливаа маргааныг зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд хэрэв тодорхой зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу харъяалагдах шүүхээр шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:**

НИЙЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
" ЮТО" ХХК-ны
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
Г. БАТЦОГТ /

ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХК-ны
Байгал орчны инженер
/М.ӨЭЛҮН /

**ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ:**

Хаяг: Монгол улс,
Улаанбаатар хот, БЗД , 26-р хороо, 404-103 тоот
Утас: 99097688, 99090313

Хаяг: Монгол улс,
Дархан-Уул аймаг, Дархан сум, 2-р баг,
Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХК-ийн төв оффисын 304 тоот
Утас: 99279734

*Зураг 44 Техникийн хаягдал тос бэлтгэн нийлүүлэх гэрээ*




*Зураг 45 Эмнэлгийн хог хаягдал түр хадгалах сав*

Уурхайн Анхан шатны тусламж үзүүлэх нэгжийн үйл ажиллагаанаас гарах аюултай хог хаягдлыг тусгай зориулалтын саванд хуримтлуулан, Гангийн үйлдвэр буюу компанийн төв байрлуу тээвэрлэн авчирч Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулсны дагуу долоо хоног бүрийн Пүрэв гаригт устгалд өгдөг.



*Зураг 46 Эмнэлгийн хог хаягдал устгалд өгч буй байдал*



БАТЛАВ:
УУЛ УУРХАЙ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА Н.БАТБАЯР

**ХОГ ХАЯГДЛЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, МЭДЭЭЛЭХ ТУХАЙ**

Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 31 дугаар зүйлийн 31.3 дахь заалт, Хог хаягдлын тухай хууль 10 дугаар зүйлийн 10.2.1 дэх заалт, 10.2.2 дахь заалт, 10.2.3 дахь заалт 10.2.5 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт, 23.4 дэх заалт, 23.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн доорх нэгж хэсгүүд хариуцсан хог хаягдлуудаа цуглуулах, ангилах, бүртгэх, хадгалах, устгуулах ажлыг зохион байгуулж, сар бүрийн 2-ны дотор Байгаль орчны инженер Э.Нандинболор /nandinbolor.e@dmp.mn/-т нийт дүн мэдээллээ хүргүүлнэ үү.

Уурхайн үйл ажиллагаанаас гарах тоосжилтыг бууруулах зорилгоор зам усалгаа хийсэн бүртгэлийг маягтын дагуу дээрх хугацаанд ирүүлнэ үү.

Хүснэгт-1. Хог хаягдлын менежментийн үүрэг хариуцлагын матриц
Хүснэгт-2. Хог хаягдал бүртгэлийн маягт
Хүснэгт-3. Зам усалгаа хийсэн бүртгэлийн маягт

Боловсруулсан:
БОХАБЭАА-ны БО-ны инженер Э.Нандинболор
Хянасан:
БОХАБЭАА-ны дарга Н.Батцэнд
Танилцсан:
ЗУГ-ын дарга Г.Ганболд
ГУУХ-ийн дарга Г.Хишигбаяр
Хүлээн авсан:
ААА-ны дарга Д.Мэндсайхан
БОХАБЭАА-ны эмч Т.Төмөрсүх
ЧХХ-ийн дарга Н.Батхуяг
ЗМА-ны дарга С.Алдарсайхан
Төмөртэй уурхайн дарга Б.Золзаяа
Төмөртолгой уурхайн дарга Р.Дамбаравжаа
ТХ-ийн дарга Г.Өлзийсайхан

Хүснэгт-1. Хог хаягдлын менежментийн үүрэг хариуцлагын матриц

| № | | | Хог хаягдлын төрөл | Хог хаягдлын код | Бүртгэл хөтлөх, гүйцэтгэгч | Гүйцэтгэл хянагч | Хяналт тавигч | Дэмжлэг үзүүлэгч: Үйлдвэр | Дэмжлэг үзүүлэгч: Уурхай |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | XXTXхууль, 4.1.4 | Энгийн | Холимог ахуйн хог хаягдал | 200301 | Кемп менежер | Аж ахуйн албаны дарга | БО-ны ахлах инженер, БО-ны инженер | БОХАБЭА А-ны дарга | Уурхайн дарга |
| 2 | | | [illegible] | 161001 | | | | | |
| 3 | | | [illegible] | 200127 | | | | | |
| 4 | Хог хаягдлын тухай хууль, 4.1.2" Аюултай хог хаягдал" | Ашигласан тос масло, бусад | [illegible] (А) | 130503 | [illegible] | Засварын мастер, механик | БО-ны ахлах инженер, БО-ны инженер | Засвар механикийн албаны дарга | Уурхайн дарга |
| 5 | | | [illegible] (А) | 160110 | | | | | |
| 6 | | | [illegible] (А) | 130501 | | | | | |
| 7 | | | [illegible] (X) | 160701 | | | | | |
| 8 | | | [illegible] (X) | 150201 | | | | | |
| 9 | | Эмнэлгийн | Хурц иртэй, үзүүртэй хог хаягдал | 180101 | Бага эмч | Эмч | БО-ны ахлах инженер, БО-ны инженер | БОХАБЭА А-ны дарга | Уурхайн дарга |
| 10 | | | Цуглуулах, устгахад тусгай шаардлага тавигддаг халдвартай хаягдал (ковид 19, хэрэглэсэн маск, бусад) (А) | 180103 | | | | | |
| 11 | | | Цуглуулах, устгахад тусгай шаардлага тавигдаагүй халдваргүй хаягдал(боолт, гипсийн боолт, даавуу, нэг удаагийн хувцас г.м) | 180104 | | | | | |
| 12 | | Химийн бодисын | [illegible] (X) | 160503 | Материалын инженер | Чанар хяналтын хэлтсийн дарга | БО-ны ахлах инженер, БО-ны инженер | БОХАБЭА А-ны дарга | Уурхайн дарга |
| 13 | | | [illegible] (X) | 160504 | | | | | |
| 14 | | | [illegible] (А) | 150109 | | | | | |
| 15 | | Бусад | Бүх төрлийн батерей, аккумлятор | 160605 | Засварын мастер, механик | Техникийн хэлтсийн дарга | БО-ны ахлах инженер, БО-ны инженер | БОХАБЭА А-ны дарга | Уурхайн дарга |
| 16 | | | Ашиглалтаас гарсан дугуй | 160101 | | | | | |
| 17 | | | Зам усалгаа | - | Диспетчер | Диспетчерийн албаны дарга | | | |

*Зураг 47 Хог хаягдлын бүртгэл хөтлөх мэдээллэх тухай*

## 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

| **Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр** | **Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт** | **Зардал, төг** | **Тайлбар** |
|---|---|---|---|
| **1. Агаар** | | | |
| Хорт хийн агууламж Азотын давхар исэл $NO_2$, Хүхэрлэг хий $SO_2$, Нүүрстөрөгчийн дутуу исэл CO, $CH_4$ | Ил уурхайн орчим<br>Хөрсний гадаад овоолгын орчим,<br>Кемпийн талбайн урд<br>ШТС<br>Баяжуулах үйлдвэрийн орчим-2,<br>Эрүүл талбай<br>Гадаад тээврийн зам | 1,600,000 | Агаарын шинжилгээний дүнгээр нийт тоос болон тоосонцорын агууламж тогтмол өндөр гарч байгаа тул тоосжилтыг бууруулах зорилгоор техникүүдэд хурдны хязгаар тогтоон мөн тогтмол зам талбайг услах ажил хийгдэж байна. |
| Агаарын тоос, тоосонцорын /PM2.5, PM10/ агууламж | | | |
| **2. Усны хяналт шинжилгээ** | | | |
| Усны химийн шинжилгээ<br>Микроэлементийн шинжилгээ<br>Микробиологийн шинжилгээ | Шүүрлийн ус<br>Шүүрлийн усан сан | 861,000 | – Уурхайн гүний худгийн усны хатуулгийн агууламж стандартаас 1.2 дахин давсан үзүүлэлттэй байна.<br>– Тиймээс бид хоолны газарт бага оврын ус цэвэршүүлэх төхөөрөмжийг суурилуулан шүүлтүүрийг улирал бүр солин ашиглаж байна. |
| | Гүний худаг | 1,148,000 | |
| | Ундны ус | | |
| **3. Хөрсний хяналт шинжилгээ** | | | |
| Хөрсний агро химийн үзүүлэлтүүд | Шимт хөрсний овоолго,<br>Эрүүл талбай<br>Уурхайн ам<br>Кемпийн талбай,<br>Хогийн цэг,<br>Баяжуулах үйлдвэр,<br>Дотоод зам дагуу<br>ШТС | 1,057,500 | – Хөрсний бохирдлын шинжилгээний дүнгээс харахад Баяжуулах орчимд авсан дээжинд сульфатын агууламж SO4 агууламж өндөр гарсан нь тус уурхайн баяжмал хүхэр ихтэй нь нөлөөлж байна. |
| Хөрсний хүнд элементүүд | | | |
| Хөрсний микробиологийн шинжилгээ | | | |
| **Нийт** | | **4,836,500** | |



БАТЛАВ.
"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР"
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.ДУГАРЖАВ

БАТЛАВ.
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УС ЦАГ УУР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА
С.АЛТАНДОЛГИОН

**ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2024 оны 03 дугаар сарын 28 — №01/2024 — Дархан-Уул аймаг

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 **Гэрээний зорилго:** Орчны бохирдлын эх үүсвэр бүхий үйлдвэр, уурхай, аж ахуйн нэгж байгууллагын уурхайн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны орчимд байгаль орчинд гарч болох хими, физик, биологийн хувьсал өөрчлөлт, агаар, усан мандал, хөрсний бохирдлын түвшинд байгаль орчны ажиглалт, судалгаа, хяналт шинжилгээ хийж, дүгнэлт өгөх

1.2 Монгол улсын агаарын тухай хуулийн 9.1.3; 9.1.4 заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10.1-3, 11.2 заалтын дагуу агаар бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн байгууллагаар орчны бохирдлын хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Нэг талаас: "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК /РД:2051303/, (цаашид "Захиалагч" гэх)-ийг төлөөлж Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хэлтэсийн дарга Н.Батцэнд.

Нөгөө талаас: Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв /РД:9023291/ (цаашид "Гүйцэтгэгч" гэх) –ийг төлөөлж УОШХ-ийн дарга М.Алимаа

(*Дээр дурдсаныг тус тусад нь "**Тал**", хамтад нь "**Талууд**" гэх*) нар дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг**

2.1. Хөтөлбөрт заасан хугацаанд шинжилгээний дээж авч, холбогдох стандартын дагуу шинжилгээг гүйцэтгэхийг шаардах;
2.2. Гүйцэтгэгчийн шинжилгээ авахад шаардлагатай унааг хариуцах;
2.3. Шинжилгээний ажлын эцэст үр дүнг шалгаж, дүгнэлтийн хамт хүлээн авах;
2.4. Гэрээнд заасны дагуу ажлын хөлсийг хугацаанд нь төлөх.

**Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

3.1. Хөтөлбөрт тусгасны дагуу судалгааны сорьц, дээжийг авч, чанарыг алдагдуулахгүйгээр лабораторийн шинжилгээнд авчрах;
3.2. Итгэмжлэгдсэн лабораторийн химийн сорилт, шинжилгээний ажлыг MNS, MNS ISO стандарт, аргачлалын дагуу заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэх;
3.3. Гүйцэтгэгч нь лабораторийн нэрийн өмнөөс үйлчилгээ гүйцэтгэх явцад тухайн байгууллагаас авсан бүх мэдээллийн нууцыг хадгалах;
3.4. Шинжилгээний үр дүнд ямар нэгэн эргэлзээтэй дүн мэдээ гарсан тохиолдолд түүнийг засах, давтан шинжилгээ хийх ба ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга, нээлттэй байх бүрэн хариуцлага хүлээх;

1 of 10

*Зураг 48 Дархан-Уул аймгийн УЦУОШТөвтэй байгуулсан гэрээ*







*Зураг 49 Дархан Уул аймгийн УЦУОШТөвийн мэргэжилтнүүд орчны хяналт шинжилгээний дээж авч буй нь*

## 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Төлөвлөсөн арга хэмжээ | Төлөвлөгөөний биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Тухайн жилийн БОМТ-г боловсруулж батлуулах, хэрэгжилтийг тайлагнах | Төмөртолгой уурхайн 2023 оны БОМТ хэрэгжилтийн тайланг хуулийн хугацаанд орон нутагт хүргүүлсэн | Дотоод зардал | |
| 2 | - Байгаль орчин хамгаалах<br>- Гал түймрээс урьдчилан сэргийлэх<br>Хөдөлмөр хамгаалал зэрэг сэдвээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах | БОХАБЭАА-наас зохион байгуулсан нийт ажилчдын сургалтанд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх сургалтыг зохион байгуулсан | Дотоод зардал | Сургалт орж байх үеийн зургийг Зураг 50-д хавсаргав |
| 3 | Үйлдвэрлэлийн зардлаар БО-ны тухай хууль, журам, стандартын биелэлтийг хангах зорилгоор дотоод хяналтыг зохион байгуулах | Дотоод хяналтын хэлтсээс хяналт шалгалт хийн, хуваарьт шаардлага хүргүүлсэн | Дотоод зардал | ДХХ-с ирүүлсэн хяналт шалгалтын тайланг “Хавсралт” хэсэгт хавсаргав. |
| 4 | Уурхайн хаалтын төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэн батлуулах | Уурхайн хаалтын чиглэлийг орон нутагтай зөвшилцөж байна | Дотоод зардал | |
| 5 | Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ /БОННҮ/ тодотгол хийлгэх | Тендер шалгаруулалтанд “Маргад очирваань” ХХК шалгаран, гэрээ байгуулж, БОННҮ-г боловсруулж батлуулсан | 32,000,000 | “Маргад очирваань” ХХК-тай байгуулсан гэрээг хавсаргав |
| **НИЙТ** | | | **32,000,000** | |




*Зураг 50 Нийт ажилчдын сургалт орж буй байдал*



БАТЛАВ: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Б. ЧАГНААДОРЖ

/огноо/

"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХХК
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

2024 оны 09 сарын 09-ны өдөр — Дархан-Уул аймаг

**Дугаар 16 /2024**

**НЭГ. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл**

Хяналт шалгалтын зорилго нь "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн 2024 оны Байгаль, орчны нарийвчилсан үнэлгээ, менежментийн төлөвлөгөөний явц, гүйцэтгэл, байгаль орчны Улсын байцаагчийн албан шаардлагын дагуу хийгдсэн ажлын төлөвлөгөө, биелэлт, дүйцүүлэн хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын гүйцэтгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж холбогдох хууль, журмын хүрээнд ажилласан эсэхэд дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, заавар зөвлөмж өгөхөд оршино.

**ХОЁР. Хяналт шалгалтын төрөл, хэлбэр**

Дотоод хяналт шалгалтын журмыг үндэслэн төлөвлөгөөт хяналт шалгалт хийнэ.

**ГУРАВ. Хяналт шалгалтын арга**

Дотоод хяналт шалгалтын журам болон бусад хууль журмын хүрээнд үйл ажиллагаа явуулсан эсэх, бүртгэл хөтлөлт, холбогдох баримт материалыг үндэслэн хяналт тавих ажлыг хийж гүйцэтгэнэ.

**ДӨРӨВ. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн**

ДХХ-ийн хяналтын ахлах мэргэжилтэн Н.Мөнхбаяр

**ТАВ. Хяналт шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах нэгж, хэлтэс, алба, цех**

1. БОХАБЭА-ийн хэлтэс
2. Төмөртэй хүдрийн уурхай
3. Төмөртолгой хүдрийн уурхай
4. СЭЗ-ийн хэлтэс
5. Улаанбаатар төмөр бэлдэх төв

*Зураг 51 Байгууллагын Дотоод хяналт шалгалтын удирдамж*


"МАРГАД ОЧИРВААНЬ" ХХК
Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, зөвлөгөө

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН
СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Төсөл хэрэгжүүлэгч: "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК
Төслийн нэр: "Төмөртолгойн төмрийн хүдрийн орд ашиглах" төсөл

БАТЛАВ:
"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Дугаржав

"Маргад Очирваань" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Эрдэнэжаргал

УЛААНБААТАР ХОТ
2023 ОН


БАТЛАВ:
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ Г.ЭНХМӨНХ

ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ С. НЯМЖАВ

ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР ХХК-НИЙ ТӨМӨРТОЛГОЙН ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРД АШИГЛАХ ТӨСӨЛ -ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН РЕГИСТРИЙН ДУГААР:
6071317

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА:
"МАРГАД ОЧИРВААНЬ" ХХК Нэр: Гарын үсэг:

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР ХХК Нэр: Гарын үсэг:

2024 ОН

*Зураг 52 Уурхайн батлагдсан БОТБТ, БОННҮ*

## 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | БОМТ-ний биелэлтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчидад тайлагнах төлөвлөгөө | БОМТ-ний биелэлтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчидад тайлагнах төлөвлөгөөний биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Дархан-Уул аймгийн БОАЖГ-т | Хуулийн хугацаанд БОМТ-ний тайланг хүргүүлсэн ба орон нутгаас заасан хугацаанд тайланг танилцуулна | Дотоод зардал | |
| 2 | Орон нутгийн иргэдэд | Хонгор сумын 2 р багийн ИНХ-д 2024 оны 03 сарын 20 өдөр Уурхайн БОННҮ-ий нэмэлт тодотгол тайланг хэлэлцүүлэн Уурхайд байгаль хамгааллын чиглэлээр хийгдэж буй ажил цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулга хийж санал солилцсон. | Дотоод зардал | Иргэдийн нийтийн хурлын протоколыг хавсаргав. |
| 3 | БОАЖЯ-ны ХБОБНУ-ын газарт | 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайланг Дархан-Уул аймгийн БОАЖГ-т танилцуулан, дэмжигдсэний дараа БОАЖЯ-ны ХБОБНУ-д хүргүүлэн, батлуулна | Дотоод зардал | |



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН 2-р БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ

45020 Дархан-Уул аймаг Хонгор сум, Зэлтэр баг

2024.3.20 № 04/01

Санал авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 18.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Хонгор сумын 2-р багийн Иргэдийн Нийтийн Хурлын ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн Хонгор сум, 2-р багийн нутаг дэвсгэрт байрлах "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн "Төмөртолгой төмрийн хүдрийн орд ашиглах" төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг дэмжсүгэй.
2. Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчныг хамгаалах, үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллах, иргэдээс гарсан саналыг харгалзан үзэхийг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн удирдлагад уламжилсугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хонгор сумын 2-р багийн Засаг даргад үүрэг болгосугай.

ДАРГА Ж.АЛТАНСҮХ

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН 2-р БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 3 сарын 20 өдөр Дугаар 04/01 Зүүнхараа

**Хонгор сумын 2 дугаар баг, мөн "Дунд худаг" гэх газруудад болсон хурлын тэмдэглэл**

Хонгор сумын 2-р багийн Иргэдийн Нийтийн хурлын ээлжит бус 8 дугаар хуралдаан 2024 оны 03-р сарын 20-ны өдрийн 11 цаг 50 минутад Хонгор сумын 2-р баг 5-р бригад, мөн 15 цаг 00 минутад 2 дугаар багийн Дунд худаг гэх газарт эхэллээ. Хуралдааныг багийн ИНХ-ын дарга Ж.Алтансүх даргалан, нарийн бичгийн даргаар Н.Нордог сонгогдож хуралдаанд 2 дугаар багийн 5 дугаар бригадын 26 иргэд цугларч хуралдаан эхлэв.

Хуралдааны дарга Ж.Алтансүх хуралдааныг нээж үг хэллээ.

Өнөөдрийн ээлжит бус хуралдаанд хүрэлцэн ирсэн та бүхнийхээ энэ өдрийн амрыг айлтгая, цаг уурын хэцүү байдалтай өвөлжилт хүндэрсэн нөхцөлд хуралдаандаа хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудал, танилцуулга хийх албан тушаалтныг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал: "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн Төмөртолгой төмрийн хүдрийн орд ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг иргэдээр хэлэлцүүлэн тайланд санал авна.

**Асуулт, хариулт:**

2 дугаар багийн иргэн Л.Тамирхүү-Энэ байгаль орчны нөлөөллийн үнэлгээний ажил чинь яг юунд хэрэгтэй вэ? Одоо л хийгдэж байгаа ажил юмуу?

- Хариулт Маргад очирваань ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн Х.Мөрөн: Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Газрын тухай хуулийн дагуу 5 жилд 1 удаа болон төслийн хүчин чадал, тоног төхөөрөмж өөрчлөгдөх тухай бүрд нэмэлт тодотгол байдлаар хийгддэг төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлж түүнийг арилгах, бууруулах, сэргийлэх арга хэмжээг төлөвлөж өгдөг мэргэжлийн эрх бүхий байгууллага хийдэг ажил юмаа. Энэхүү ажлыг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК нь өмнөх тайлангийн хүчин төгөлдөр хугацаа дуусгавар болсон тул дахин хийлгэж байгаа.

2 дугаар багийн иргэн Г.Баасандорж- Танай компани Хонгор суманд ямар бодитой хөрөнгө оруулалт хийх вэ?

*Зураг 53 Иргэдийн нийтийн хурлын протокол*

## 13. ДҮГНЭЛТ

2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 53 ажлыг 244,388,764 төгрөгийн төсвөөр хийж гүйцэтгэсэн байна.

| № | Арга хэмжээ | Зардал, төг |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 47,956,996 |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 26,100,000 |
| 3 | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 12,835,268 |
| | Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөө | 59,480,000 |
| | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |
| | Нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө | 53,040,000 |
| | Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө | |
| | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 8,140,000 |
| | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 4,836,500 |
| | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 32,000,000 |
| 4 | Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө | - |
| **Нийт** | | **244,388,764** |

**14. Хавсралт:**

1. Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хуулбар
3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнгүүд
4. Хайгуулын ажил, ТЭЗҮ-г хүлээн авсан тушаал, тэмдэглэл
5. БОХ-3 маягт. Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн жилийн мэдээ
6. Эрх бүхий байгууллагуудаас гүйцэтгэсэн ажлыг нь хүлээж авсан актын хуулбарууд
7. Хуваарьт аудитын дүгнэлт, зөвлөмж ба түүний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан
8. Дотоод хяналтын хэлтсээс ирүүлсэн тайлан ба түүний дагуу авч хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл
9. Байгууллагын хариуцлагын даатгалын хуулбар
10. Нөөц ашигласны төлбөр тушаасан баримтын хуулбар
11. Нөөцийн хөдөлгөөний тайлангийн хуулбар
12. Хилээр экспортод гаргасан бүтээгдэхүүний талаар гаалийн албанаас гаргасан мэдээ

*Жич: Хавсралтыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар 29-ний өдрийн А/618 тоот тушаалын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 3 дугаар хавсралтыг үндэслэн боловсруулсан. Мөн уг хавсралтаас дээр дурьдагдсан болон уурхайн үйл ажиллагаатай холбоогүй хавсралтуудыг хассан болно.*